

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүн

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
ҮАГ-ын харьяа Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар.....3
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Аудитын менежер О.Амаржаргал	Бүлэг 1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө хууль журмын дагуу зарцуулагдаж байна уу.....5-16
Аудитор Г.Бадар-Ууган	Бүлэг 2 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байна уу.....16
	Дүгнэлт17
	Зөвлөмж18
2014 оны 04 дугаар сарын 29	
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70272582, 70283204 дугаарын утас, 0127222582 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ:	
Төв аймаг Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

СТСХ	Санхүү Төрийн Сангийн хэлтэс
ХХҮХ	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АГ	Аудитын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ХЭБ	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудитораас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж үр дүнг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд танилцуулахад тус аудитын зорилт оршино.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах үндсэн асуудлаар аудитыг гүйцэтгэнэ.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа хуулийн дагуу хэрэгжсэн үү?
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө хууль журмын дагуу зарцуулагдаж байна уу?

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад 2013 оны аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааны мэдээ, тайлан, “ХААН банк”, “Хас банк”, Төрийн банк тэдгээрийн орон нутаг дах салбар нэгж, холбогдох байгууллагыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгааны дүнг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглана. Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрийн аудитын тухай хууль
- МУ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоол
- Хөдөлмөрийн сайдын 2013 оны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах түүнд хяналт тавих журам
- Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам
- Холбогдох бусад ЗГ-ын тогтоол, шийдвэр журам

6. Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитын тайланд аудитын зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт судалгаа, холбогдох байгууллагын саналыг хавсаргалаа.

7. Аудит хийх бүрэлдэхүүн

Аудитыг Төв аймгийн АГ-ын аудитын менежер О.Амаржаргал удирдан аудитор Г.Бадар-Ууган аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

1.1 ХЭДСангийн хөрөнгөөс машин, тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.**2.40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр**

Төв аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны батлагдсан төсөвт 40-өөс дээш болон ахмад настны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 170 хүнийг хамруулж 34680.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар 146 иргэн хамрагдаж 31226.9 мянган төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан байна. Тус хөтөлбөрт хамрагдсан иргэдэд шилжүүлсэн мөнгөн гүйлгээний харилцахын гүйлгээг холбогдох анхан шатны баримттай тулган хөтөлбөрт хамрагдсан иргэдийг тулган шалгахад тус хөтөлбөрт нийт 152 иргэн хамрагдаж 28736,3 мянган төгрөгийн зардал зарцуулсан байна. Тус хөтөлбөрт хамрагдсан нийт 152 иргэний 125 иргэн нь ХХҮХэлтсийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, 27 иргэн бүртгэлгүй байна. Бүртгэлгүй 27 иргэний 25 нь 55-аас дээш насны, мэргэжлээрээ сүүлийн 10-аас дээш жил тасралтгүй ажилласан, ажил эрхэлж орлого олдоггүй, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн эмзэг бүлгийн иргэдтэй ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай, дадлага, туршлагатай ахмад насны иргэд байгаа ба үлдсэн 2 иргэн нь 40-өөс дээш, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажил хайгч иргэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн захирлын 2013 оны А/18 тоот тушаалаар 40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдамжийг баталсан бөгөөд тус удирдамжинд хөдөлмөрийн хэлтэс нь 40-өөс дээш насны ажил хайгч иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх аж ахуй нэгж, байгууллага, мөн зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай, дадлага, туршлагатай ахмад насны иргэдийг орон нутгагтаа хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр 3-р сард төсөвтөө багтаан хэлэлцүүлэн батлуулж, 4 дүгээр сард багтаан сонгон шалгаруулах гэсэн боловч тус удирдамжийг мөрдөж ажиллаагүй байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн материалыг ХХҮХэлтсийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлтэй тулган баталгаажуулах явцад санхүүжилтийн купоноо 9-р сард авсан боловч мэдээллийн санд бүртгэл нь 12-р сард хийгдсэн тохиолдол нилээдгүй гарч байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ахлах мэргэжилтний тайлбараар сумдын мэдээллийн ажилтан хөтөлбөрт хамрагдсан иргэдийн судалгааг хугацааа хоцоруулж өгдөгтэй холбоотой тийм асуудал цөөнгүй гардаг гэсэн тайлбар өгөв. Мөн хөтөлбөрт хамрагдсан иргэн нь тухайн санхүүгийн дэмжлэгийг купоноор хэд хэдэн газраас худалдан авалт хийж байгаа учраас тулган баталгаажуулахад хүндрэлтэй байлаа. Тухайн санхүүгийн дэмжлэгээр олгож байгаа купоны ард үйлчилгээ авсан иргэд, үйлчилгээ үзүүлсэн байгууллага, иргэн нь купонд тухай бүр тэмдэглэгээ хийж баталгаажуулах ёстой боловч ихэнх купоны ард талын тэмдэглэх хэсэгт тэмдэглэгдсэн мөнгөн дүнгийн нийлбар 200.0 төгрөгийн дүнд хүрэхгүй зарим нь дутуу бичигдсэн байна. Эко эргүүл ажлын хүрээнд 8 хүнийг ажлуулан нийт 387200

төгрөгийн зардлыг 40 дээш насны ахмад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлаас гаргасан байна.

40-өөс дээш хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэний хамруулах хөтөлбөрт хамрагдсан иргэдийн материалаас ХХҮХэлтсийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй

- НН69122165 дугаартай Цэрэнбалжир овогтой Саран 200.0 мянган төгрөг,
- НЙ66092909 дугаартай Дүгэр овогтой Нарантуяа 200.0 мянган төгрөг
- НК70112902 дугаартай Дашбилэг овогтой Ариунаа 200.0 мянган төгрөг
- НМ40041510 дугаартай Оргил овогтой нэргүй 200.0 мянган төгрөг тус тус олгосон зөрчил илэрсэнд акт бичигдлээ.

3. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр

Төв аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь 2013 онд нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд 1000 хүнийг хамаруулж 150000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тайланд онд 807 иргэнийг хамруулж 152674.6 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан төсвөөс 2674.6 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. Сэргэлэн сумын Засаг даргын 2013 оны 05 сарын 01-ний 190 дугаар захирамжаар сэргэлэн сумын ЗДТГ-ын худгийн засварын ажлыг хийгэх зорилгоор Сэргэлэн сумын ажилгүй 10 иргэнийг хамруулан 14 хоногийн хугацаатай ажиллуулан засварын ажлыг хүлээлцсэн акт үйлдэн хүлээн авсан байна. Тухайн ажлыг ажил гүйцэтгэсэн 10 хүнд тус бүр 168.0 мянган төгрөгөөр тооцон НДШ, ХХОАТ-ын дагуу шимтгэл, татварыг суутган гарт олгох дүнг ажилд хамрагдсан хүмүүсийн дансанд тус тус шилжүүлэн ажилласан байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14.6-д нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна. МУ-ын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/59 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлэх нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хэмжээний 2-т усжуулалтын ажил, худаг гаргах, засварлах ажлын хөлс нь цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр олгоно гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайн заалтаар нэг иргэнд 187199 төгрөг олгохоор тооцогдож байна. Мөн Зуунмод сумын Номт багийн нутаг дэвсгэр төв цэцэрлэгийн талбайд 200 ширхэг модны нүх ухах бэлтгэх, музейгээс хот хоорондын зорчигч тээврийн зогсоол хүртэлх нийтийн эзэмшлийн 1000 м газрын шороон хөрсийг хуулж хар шороо, бууц тарааж, зүлэг тарихад бэлэн болгох, газар шорооны ажил хийж ногоон байгууламж шинээр байгуулах зорилгоор Зуунмод сумын ажилгүй 24 иргэнийг ажиллуулан НДШ, ХХОАТ –ыг хассан дүнгээр нийт 2227.2 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2012 оны А/59 тоот тушаалын 6-д хот суурийн газрын нийтийн эзэмшлийн гудамж, талбай засаж тохижуулах, мод суулгах, зүлэгжүүлэх нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тооцож олгоно гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй нэг иргэнийг дунджаар 120.0 мянган төгрөгөөр цалинжуулан нийт 369.9 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Мөн 2013 оны 06 сарын 25-нд Архуст суманд нийтийг хамарсан ажил зохион байгуулан сумын ажилгүй байгаа 11 иргэнийг авч төвийн суурин өрхийн хашааг зостож, хаалгыг ногоон өнгийн будгаар будан хээ тавьж, хашааны нүүрэн талын банзыг шахаж барих ажлыг хийж гүйцэтгүүлэн ажлын хөлсөнд нийт НДШ, ХХОАТ-ыг хассан дүнгээр 2995.2 мянган төгрөгийн цалин

олгосон нь мөн дээрх тушаалыг зөрчин 492.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах гэрээ болон ажилд хамрагдсан иргэдийн цагийн бүртгэл, ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхний хуулбар, тухайн нутаг дэвсгэрийн засаг даргын захирамж, болон МХГ-ын дүгнэлт, хийгдсэн ажлын талаар зураг авалт хийж баталгаажуулан тайланд хавсаргасан бүрэн албажуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14.6-д нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна гэсэн заалтыг мөрдөж ажиллахгүй байна.

4. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд 2013 онд 1000 хүнийг хамруулж 150000.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар төсөвлөгдсөнөөс 126 хүнийг хамруулж 23721.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Сэргэлэн сумын Засаг даргын 2013 оны 05 сарын 01-ний 190 дугаар захирамжаар сэргэлэн сумын ЗДТГ-ын худгийн засварын ажлыг хийгэх зорилгоор Сэргэлэн сумын ажилгүй 10 иргэнийг хамруулан 14 хоногийн хугацаатай ажиллуулан засварын ажлыг хүлээлцсэн акт үйлдэн хүлээн авсан байна. Тухайн ажлыг ажил гүйцэтгэсэн 10 хүнд тус бүр 168.0 мянган төгрөгөөр тооцон НДШ, ХХОАТ-ын дагуу шимтгэл, татварыг суутган гарт олгох дүнг ажилд хамрагдсан хүмүүсийн дансанд тус тус шилжүүлэн ажилласан байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14.6-д нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна. МУ-ын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/59 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлэх нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хэмжээний 2-т усжуулалтын ажил, худаг гаргах, засварлах ажлын хөлс нь цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр олгоно гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайн заалтаар нэг иргэнд 187199 төгрөг олгохоор тооцогдож байна. Мөн Зуунмод сумын Номт багийн нутаг дэвсгэр төв цэцэрлэгийн талбайд 200 ширхэг модны нүх ухаж бэлтгэх, музейгээс хот хоорондын зорчигч тээврийн зогсоол хүртэлх нийтийн эзэмшлийн 1000 м газрын шороон хөрсийг хуулж хар шороо, бууц тарааж, зүлэг тарихад бэлэн болгох, газар шорооны ажил хийж ногоон байгууламж шинээр байгуулах зорилгоор Зуунмод сумын ажилгүй 24 иргэнийг ажиллуулан НДШ, ХХОАТ –ыг хассан дүнгээр нийт 2227.2 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2012 оны А/59 тоот тушаалын 6-д хот суурийн газрын нийтийн эзэмшлийн гудамж, талбай засаж тохижуулах, мод суулгах, зүлэгжүүлэх нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тооцож олгоно гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй нэг иргэнийг дунджаар 120.0 мянган төгрөгөөр цалинжуулан нийт 369.9 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Мөн 2013 оны 06 сарын 25-нд Архуст суманд нийтийг хамарсан ажил зохион байгуулан сумын ажилгүй байгаа 11 иргэнийг авч төвийн суурин өрхийн хашааг зостож, хаалгыг ногоон өнгийн будгаар будан хээ тавьж, хашааны нүүрэн талын банзыг шахаж барих ажлыг хийж гүйцэтгүүлэн ажлын хөлсөнд нийт НДШ, ХХОАТ-ыг хассан дүнгээр 2995.2 мянган төгрөгийн цалин олгосон нь мөн дээрх тушаалыг зөрчин 492.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Тооцооллуудыг хүснэгтээр харуулав.

**Зуунмод сумын номт багийн нийтийн эзэмшлийн гудамж тайлбайг тохижуулах,
зүлэгжүүлэх ажлын хөлсний тооцоо**

№	Нэр	ХЭДСан		Аудит				
		Ажилласан цаг	Гарт олгосон	Олгох ёстой	НДШ	ХХОАТ	Гарт	Илүү олгосон
1	Б.Алтанцэцэг	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
2	Б.Долоонжин	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
3	Г.Алтаншагай	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
4	Ж.Пүрэвжав	72	86,400	90,257	9,026	9,026	72,205	14,195
5	Ц.Даваахүү	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
6	Х.Батсайхан	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
7	С.Энхбат	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
8	А.Цэдэвсүрэн	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
9	Б.Чулуундорж	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
10	Н.Батсүх	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
11	Т.Ганбат	72	86,400	90,257	9,026	9,026	72,205	14,195
12	А.Ууганбаатар	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
13	Ц.Гүнсэнцэцэг	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
14	С.Жаргал	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
15	Ц.Өлзийбат	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
16	Б.Төрмөнх	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
17	Ц.Баасанцэнд	64	76,800	80,228	8,023	8,023	64,183	12,617
18	С.Болдбаатар	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
19	Р.Эрдэнэчимэг	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
20	П.Пүрэвсүрэнп	76	96,000	95,271	9,527	9,527	76,217	19,783
21	К.Ундрах-оргил	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
22	Г.Пүрэвдулам	80	96,000	100,285	10,029	10,029	80,228	15,772
23	Л.Нямосор	72	86,400	90,257	9,026	9,026	72,205	14,195
24	Б.Наранцэцэг	56	67,200	70,200	7,020	7,020	56,160	11,040
Нийт			2,227,200	2,321,602	232,160	232,160	1,857,282	369,918

Архуст сумын нийтийг хамарсан ажил үйлчилгээний хөлсний тооцоо

№	Нэр	ХЭДСан		Аудит					
		Ажилласан цаг	Гарт олгосон	Нэг цагт ногдох хөлс	олговол зохих	НДШ	Ашиг	Гарт олгох ёстой	Илүү олгосон цалин
1	Г.мягмарсүрэн	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
2	Д.Даваажав	128	153,600	1,254	160,456	16,046	16,046	128,365	25,235
3	С.Нэргүй	72	86,400	1,254	90,257	9,026	9,026	72,205	14,195
4	Б.Лантуу	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
5	Н.Найдансүрэн	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
6	Б.Цэвэлсүрэн	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
7	Д.Уртнасан	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
8	Л.Адьяа	272	326,400	1,254	340,970	34,097	34,097	272,776	53,624
9	Т.Баасансүрэн	200	240,000	1,254	250,713	25,071	25,071	200,570	39,430
10	Б.Дэлгэрцэцэг	216	259,200	1,254	270,770	27,077	27,077	216,616	42,584
11	К.Амаандик	248	297,600	1,254	310,884	31,088	31,088	248,707	48,893
			2,995,200	13,789	3,128,898	312,890	312,890	2,503,119	492,081

2013 оны эхний хагас жилийн байдлаар нийтийг хамарсан ажил үйлчилгээнд олгогдох цалинг тооцож олгохдоо Монгол Улсын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын ажлын хөлс, зардлын хэмжээ тогтоох тухай 2012 оны 04 сарын 30-ний А/59 тоот тушаалаар батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлэх нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардлын хэмжээний дагуу бодож олгоогүй байна.

5.Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар ажилгүй 88 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй болон 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа 4 иргэнийг хамруулан “Баянгол ТББ”, “Арука МСҮТөв”, “Лонда ПС ХХК”, “Өрхийн аж ахуйн агуу боломж ТББ”, “Хүчит зам” сургалтын төвүүдэд замчин, үсчин гоо сайханч, касс няравын сургалтанд хамруулан гэрчилгээжүүлсэн байна. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд нэг суралцагчид мэргэжлийн чиглэлд ногдох зардлыг хөдөлмөр эрхлэлтийн сургалтын батлагдсан төсвөөс нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын дээд хэмжээг тогтоох тухай 2012 оны А/41 тоот тушаалын дагуу олгож 2013 оны эхний хагас жилийн байдлаар 11552.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдийн нэг суралцагчийн хоолны зардлыг тогтоосон хэмжээний дагуу хүнд хоол унааны зардалд 168.0 мянган төгрөгийг зарцуулан холбогдох баримтыг бүрдүүлэн ажилласан байна. Хөдөлмөрийн хэлтсийн өөрийн судалгаагаар сургалтанд хамрагдсан иргэдийн 82 хувь нь байнгын болон улирлын ажлын байраар хангагдсан байна. Тухайн судалгааг сургалтанд хамрагдсан иргэдээс өөрсдөөс нь утсаар мэдээлэл авч байгаа нь судалгаа бодитой гараагүй ба ажлын байртай болсныг нотлох НДШ төлсөн тухай мэдээлэл, тушаалыг үндэслэл болгоогүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг ажлын эрэлтийг үндэслэн сургалтыг зохион байгуулан иргэдийг сургалтанд хамруулаагүй байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2013 онд ХЭҮЗ-ийн шийдвэрээр ХЭБ-уудын чадавхи бэхжүүлэх, сайжруулах гэсэн нэрээр 124.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6 сард Хашхан ХХК, Саммит компьютер технологи ХХК-уудаас 56.2 сая төгрөгийн тавилга, компьютер тоног төхөөрөмж бэлтгэсэн байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.3-т “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн үйл ажиллагаа болсон байна.

2.1 Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу явагдаагүй байна.

Сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөгөө авчирч үзүүлээгүй ба сангийн үйл ажиллагааг явуулах төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

2.2 Сангийн хөрөнгөөр жижиг зээл олгох асуудал журмын дагуу олгогдсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ажлын байр бий болгох жижиг зээлийг 2013 онд Хөдөлмөрийн сайдын 2013 оны 07 сарын 18-ны өдрийн 152 тоот тушаалын дагуу жижиг зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулах эрхийг Хөдөлмөрийн хэлтэст шилжүүлсэнтэй холбогдуулан зээлийн эх үүсвэрийг байршуулах банкаа журмын дагуу

банк сонгон шалгаруулах ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Нямсүрэнгээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүтэйгээр байгуулан банк сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй зарлан орон нутгийн арилжааны Хас, Хаан банкууд материалаа ирүүлсэнээс Хаан банк шалгуур үзүүлэлтийг ханган ХЭДСангийн 2013 оны эх үүсвэр 500.0 сая төгрөгийн жижиг зээлийг олгох эрхтэй болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 12.2 дах заалтыг үндэслэн Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Л.Болдбаатар, Хаан банкны Төв аймаг дахь салбарын захирал Б.Золбаяр нар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2013 оны 08 сарын 19-ний өдрөөс эхлэн 2015 оны 08 сарын 19-нийг хүртэл байгуулсан байна. Тус гэрээгээр банкинд байршуулах эх үүсвэрийн хэмжээ 500.0 сая төгрөг бөгөөд зээлийн хүүг сарын 0,85 хувь, хугацааг 24 сар хүртэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банкинд байршуулсан зээлийн эх үүсвэр 500.0 сая төгрөг болон зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдлийг Монгол банкин дахь харилцах дансны хөрөнгөөр сангийн өмнө үл маргах журмаар бүрэн хариуцах тухай Төв банкныхаа баталгааг нотариатаар баталгаажуулж гэрээнд хавсаргахаар тус тус тусгаж өгсөн байгаа нь МУ-ын засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 2-р хавсралтад заагдсан зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдлийг сангийн өмнө хариуцахаа илэрхийлж баталгаа гаргасан байх гэсэн заалтыг мөрдөж ажиллаж байна. Мөн тус гэрээнд банк нь зээл авахыг хүссэн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд шинээр бий болох ажлын байрны тоо, хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажилгүй иргэн, эмзэг бүлгийн иргэдээс ажилд авах тоо зэргийг харгалзан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 5.0 сая төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд 10.0 сая төгрөгийн зээлийг сарын 0.85 хүүтэйгээр хоёр жил хүртэл хугацаагаар олгоно гэсэн заалт оруулж Засгийн газрын 375 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.8 дахь заалтыг мөрдөж ажилласан байна.

Гэрээнд заагдсаны дагуу аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний банкны зээл олгох шалгуурыг ханган зээл авах боломжтой болсон малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо иргэнтэй ажлын байр бий болгох гэрээ байгуулж, ажлын байр бий болгох талаарх тодорхойлолтыг банкинд гарган өгч зээлийг олгож байна.

ЖДҮ-ийг дэмжих сангаас олгох зээл

Монгол Улсын хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 сарын 19-ний А/44 тоот тушаалаар батлагдсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмын дагуу Төв аймгийн ИТХ-ын 2013 оны 03 сарын 27-ний өдрийн 45 тоот тогтоолоор жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн төсөл сонгон шалгаруулах үүрэг бүхий дэд комиссыг даарх бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Үүнд:

Комиссын даргаар аймгийн Засаг дарга Д.Баярбат

дэд даргаар аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Л.Болдбаатар

Нарийн бичгийн даргаар Хөдөлмөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Отгонхуяг

Гишүүдэд: аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Чулуунбат, ЖДҮ төсөл хөтөлбөр, сургалтын мэргэжилтэн Ж.Батчимэг, Хаан банкны Төв аймгийн салбарын захирал Г.Золбаяр, Хадгаламж банкны Төв аймаг дахь тооцооны төвийн эрхлэгч Д.Гантуяа, Төв аймгийн АОЭздийн холбооны гүйцэтгэх захирал Р.Алтанцэцэг, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ч.Дашдэмбэрэл, Төв аймгийн ХАҮТ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Жаргалант сумын Засаг дарга, газар тариалан эрхлэгчдийн аймгийн холбооны гишүүн Д.Ганболд гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй дэд комиссыг байгуулсан байна.

ЖДҮ-ийг дэмжих зээлийн төслийг сонгон шалгаруулах Аймгийн дэд комиссын анхдугаар хуралдаанаар 2014 оны 08-ний өдрийн 09 цагаас эхлэн 04-р сарын 29-ний 18 цаг хүртэл дуустал аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн байранд хүлээн авахаар шийдвэрлэж тавигдах шаардлага бүрдүүлэх материалыг орон нутгийн телевиз болон ТҮ-9 телевиз, сонингийн заруудад болон сумдын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн тоот явуулах ил тод нээлттэй байдлыг ханган ажиллахаар шийдвэрлэсэн байна.

Төв аймгийн Засаг даргын 2013 оны 04 сарын 09-ний А/177 тоот захирамжаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд комисс ажиллах журмыг баталж 2010 оны 12 сарын 17-ний өдрийн 638 тоот захирамжийг хүчингүй болгосон байна.

Аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төслийг шалгаруулах дэд комиссын хурлын 2013 оны 05 сарын 16-нд 02 тэмдэглэлээр 11 хүнээс 10 хүний ирцтэйгээр аймгийн ЖДҮ-ийг дэмжих төсөл сонгон шалгаруулах хурлыг эхлүүлсэн байна. Тус хуралд ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй төсөлд хамрагдахаар ирүүлсэн Зуунмод, Эрдэнэ, Баянцагаан, Бүрэн, Баяндэлгэр, Борнуур, Бүрэн, Лүн, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Алтанбулаг, Аргалант, Баянхангай, Эрдэнэсант, Сэргэлэн, Архуст, Баянчандмань, Баянцогт, Мөнгөнморьт, Угтаалцайдам, Баян, Сэргэлэн зэрэг 22 сумын 84 төслийн 3.8 тэрбум төгрөгийн төслийг хэлэлцэж үүнээс хөнгөн үйлдвэрийн 8, газар тариалангийн 2, МАА-4, Барилгын салбарын 1, худалдаа үйлчилгээний 4, нийт 546.0 сая төгрөгийн 19 төслийг сонгон шалгаруулж Хаан, Хас, Төрийн банк зэрэг арилжааны банкуудад хүргүүлснээр хөнгөлөлттэй зээлийг иргэд, ахуйн нэгжүүдэд олгосон байна. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг дамжуулан олгох үйл ажиллагаанд оролцох арилжааны банкуудыг Хөдөлмөрийн яамнаас сонгон шалгаруулсан учраас хийгдсэн гэрээ, зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдлийг даах баталгаа зэргийг гаргаж байна.

Төсөл сонгон шалгаруулах комисс болон дэд комисс нь тухайн жилд дэмжих салбар чиглэлээ тодорхойлоогүй олон нийтэд ил тод зарлах, төсөл шалгаруулах ажлыг урсгал байдлаар зохион байгуулж байгаа дутагдал байна. Мөн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацаа болон хөнгөлөлттэй зээлийн явцыг тухай бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлдэггүй, дэмжигдээгүй төслийн шалгараагүй шалтгаан үндэслэлийг зээл хүсэгчдэд албан бичгээр хариу мэдэгддэггүй, иргэдийг төсөл бичих болон аж ахуй эрхлэх анхан болон дунд шатны сургалтыг үе шаттай зохион байгуулаагүй байна.

2.3 Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн ашиглалт үр дүнг тооцож ажиллаагүй байна.

ХЭДСангаас тайлант онд сум хөгжүүлэх сангийн санхүүжилтэнд 1700.0 сая төгрөгийн төсөв батлагдаж суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан МУ-ын хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 сарын 11-ний өдрийн А/38 тоот тушаалаар баталсан сум хөгжүүлэх сангийн хөрөнгө зарцуулах хуваарийн дагуу 27 суманд дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

1. Алтанбулаг сумын сум хөгжүүлэх санд	60000.0
2. Аргалант сумын сум хөгжүүлэх санд	50000.0
3. Архуст сумын сум хөгжүүлэх санд	50000.0
4. Батсүмбэр сумын сум хөгжүүлэх санд	75000.0
5. Баян сумын сум хөгжүүлэх санд	50000.0
6. Баяндэлгэр сумын сум хөгжүүлэх санд	50000.0
7. Баянжаргалан сумын сум хөгжүүлэх санд	50000.0

8. Баян-Өнжүүл сумын сум хөгжүүлэх санд	50000.0
9. Баянхангай сумын сум хөгжүүлэх санд	50000.0
10. Баянцагаан сумын сум хөгжүүлэх санд	50000.0
11. Баянцогт сумын сум хөгжүүлэх санд	50000.0
12. Баянчандмань сумын сум хөгжүүлэх санд	60000.0
13. Бүрэн сумын сум хөгжүүлэх санд	60000.0
14. Дэлгэрхаан сумын сум хөгжүүлэх санд	50000.0
15. Жаргалант сумын сум хөгжүүлэх санд	75000.0
16. Заамар сумын сум хөгжүүлэх санд	75000.0
17. Лүн сумын сум хөгжүүлэх санд	50000.0
18. Мөнгөнморьт сумын сум хөгжүүлэх санд	50000.0
19. Өндөрширээт сумын сум хөгжүүлэх санд	50000.0
20. Сэргэлэн сумын сум хөгжүүлэх санд	50000.0
21. Сүмбэр сумын сум хөгжүүлэх санд	50000.0
22. Угтаал сумын сум хөгжүүлэх санд	50000.0
23. Цээл сумын сум хөгжүүлэх санд	50000.0
24. Эрдэнэ сумын сум хөгжүүлэх санд	60000.0
25. Эрдэнэсант сумын сум хөгжүүлэх санд	60000.0
26. Зуунмод сумын сум хөгжүүлэх санд	265000.0
27. Борнуур сумын сум хөгжүүлэх санд	60000.0

Төв аймгийн Сумдаас Хөдөлмөрийн хэлтэст ирүүлсэн мэдээгээр 2013 онд нийт 1002 төсөлд 4862.6 сая төгрөгийн зээл олгогдож 2013 онд төлөвлөгдсөн 600 шинэ ажлын байр бий болгохоос хөдөлмөрийн хэлтэст ирүүлсэн мэдээгээр 593 байнгын ажлын байр бий болсон буюу 98.8 хувийн биелэлттэй гэсэн мэдээтэй байна. Тус мэдээг тухайн ажилчдын НДШ төлөлтийг тулган баталгаажуулж мэдээллийн санд бүртгэж байна. Сум хөгжүүлэх сангаас 2013 онд бий болсон ажлын байрыг сумдаар үзүүлвэл:

Алтанбулаг сум 18, Аргалант сум 6, Архуст сум 31, Батсүмбэр сум 29, Баян сум 20, Баяндэлгэр сум 16, Баянжаргалан сум 3, Баян-Өнжүүл сум 14, Баянхангай сум 2, Баянцагаан сум 18, Баянцогт сум 31, Баянчандмань сум 30, Борнуур сум 28, Бүрэн сум 7, Дэлгэрхаан сум 15, Жаргалант сум 36, Заамар сум 39, Зуунмод сум 77, Лүн сум 29, Мөнгөнморьт сум 22, Өндөрширээт сум 10, Сүмбэр сум 15, Сэргэлэн сум 16, Угтаалцайдам сум 29, Цээл сум 18, Эрдэнэ сум 15, Эрдэнэсант сум 19, **нийт 593** ажлын байр бий болжээ.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн 2013 оны 08 сарын 12-ний 2/270 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын дагуу олгохгүй, үр дүн муутай, төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг 134-р тогтоолын 3.3 заалтыг зөрчин байгуулсан, зээлийн талаарх мэдээлэл иргэд олон нийтэд ил тод нээлттэй биш, зориулалт бусаар танил талдаа олгодог санал гомдол их гардаг, сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэлт ихтэй, зээлээ зориулалтын дагуу ашигладаггүй, тогтвортой байнгын шинэ ажлын байр бодитойгоор бий болгодоггүй, сумдын засаг дарга, төрийн сан хугацаатай тайлан, мэдээг маягтын дагуу гаргахгүй, хугацаа хоцроох, ирүүлсэн тайлан мэдээ нь боловсруулалт муутай чанарын шаардлага хангахгүй, холбогдох хэлтэстэй эргэх холбоо муутай ажиллаж байгаа зэргийг дурдаад сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар 7 зүйл бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна. Мөн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2013 оны 10 сарын 2/376 тоот албан бичгээр зориулалт бусаар ашигласан болон хугацаа

хэтэрсэн зээлийг яаралтай буцаан төлүүлж сангийн эх үүсвэрт төвлөрүүлэх, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, Зээлээ зориулалт бусаар зарцуулсан, хугацаа хэтрүүлсэн зээлдэгчийн мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй мэдээлэх, сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг дэмжин шийдвэрлэхдээ төсөл хэрэгжүүлэгчийн төлбөрийн чадвар, идэвх чармайлт, дадлага туршлага зэргийг сайтар судласаны үндсэн дээр дэмжих, эргэн төлөлтийн хуваарийг сар бүр үндсэн зээл, зээлийн хүүгийн хамт төлөх байдлаар гэрээнд заавал тусгаж өгөх, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөл нь журамд заасны дагуу сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг ИТХ болон Тэргүүлэгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, үр дүнг сумын иргэдэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах зэрэг талаар сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах, зөрчил дутагдлыг арилгах зорилгоор арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт дахин явуулсан байна. Аймгийн Засаг даргын 2013 оны 10 сарын 25-ний А/594 тоот захирамжаар сум хөгжүүлэх сангийн үр дүнг сайжруулах тухай сумдын засаг дарга нарт 2009-2012 онд сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр олгосон зээлийн эргэн төлөлтийг тооцон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг энэ ондоо багтаан бүрэн төлүүлэх арга хэмжээг авч ажиллах, сум хөгжүүлэх сангийн 2012, 2013 оны эх үүсвэрээр бий болсон шинэ ажлын байрыг НДШ төлөлтөөр баталгаажуулан 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хөдөлмөрийн хэлтэст ирүүлэх, МУ-ын Засгийн газрын 134-р тогтоолын дагуу зээл олголт, зээлийн эргэн төлөлтийн тайланг улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлж байхыг даалгасан захирамжийг хүргүүлсэн боловч сумдууд хэрэгжилтийн талаар хөдөлмөрийн хэлтэст хүргүүлж ажиллаагүй байна. Хэдий төлөвлөсөн ажлын байрны биелэлт 98.8 хувиар бий болсон ч дээрх Хөдөлмөрийн хэлтсийн даргын зөвлөмж, аймгийн Засаг даргын захирамж зэргээс дүгнэхэд сум хөгжүүлэх сангийн зээл олголт зориулалт бусаар олгогдож, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

2.4 Сангийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжиж, үр нөлөөгөө үзүүлсэн үү.

Жижиг зээл

ХЭДСангаас олгогдож байгаа жижиг зээлийн хувьд банкаар дамжуулан олгогдож байгаа бөгөөд нийт эх үүсвэр болох 500.0 сая төгрөгөөс 145 иргэнд 322.0 сая төгрөгийн зээл олгогдсон ба 80 ажлын байр хадгалагдан үлдэж 241 ажлын байр шинээр бий болсон байгаа нь зээлийн ашиглалт үр дүнтэй ажлын байрны тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээл

Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зарим аж ахуйн нэгж болон иргэд зээлийг бичсэн төслийн зориулалтаар ашиглаагүй, зээл авснаас хойш одоо болтол үйл ажиллагаа явуулаагүй, эргэлтийн хөрөнгө дутагдсан эх үүсвэрээ нөхөх байдлаар ашиглаад буцааж төлдөг зэрэг зөрчлүүд гарсаар байна. Аудитын явцад яамнаас шууд олгосон зээлүүдийн олголт, хэрэгжилтэнд хяналт тавьж буй байдлыг сум орон нутгийн удирдлагуудаас тодруулахад зээлийн талаар юу ч мэдэхгүй ямар нэгэн хяналтгүй байна. Жишээлбэл: ХХААХҮЯ-аас 2012 онд Жаргалант суманд “Чез-энд эл” ХХК 250.0 сая төгрөгийг 715 гахайны эрчимжсэн аж ахуй байгуулах, Агро-альфа ХХК 100.0 сая төгрөгийг 200 тн хүнсний механикжсан зоорь барих, Хөдөлмөрийн Яамнаас 2013 онд Аргалант суманд “Түмэнд хурай” ХХК 1000.0 сая төгрөгийг Зоорийн барилгын өргөтгөл хийх, Цээл суманд “Дэлгэр цээл” ХХК 350.0 сая төгрөгийг малын тэжээлийн үйлдвэр барих,

Баянцогт суманд “Замбативийн шим” ХХК 711.0 сая төгрөгийг “Махны чиглэлийн тахиа үржүүлэх, Баянчандмань суманд “Цэнгоулд” ХХК 1.5 тэрбум төгрөгийг Сүүний үйлдвэр байгуулах зэрэг төсөл хэрэгжүүлэхээр нийт 3.9 тэр бум төгрөгийн зээл авсан боловч тухайн орон нутагт энэхүү төслүүд хэрэгжээгүй, зориулалтын бусаар зарцуулагдаж байгаа зөрчил илэрлээ.

Аймгийн Татварын хэлтсээс тодруулахад “Цэнгоулд” ХХК нь аймаг сум орон нутагт, бүртгэлгүй уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Баянчандмань суманд төслөө хэрэгжүүлээгүй байна. Энэ нь ЖДҮ-ийн тухай хуулийн 8.1.4 заалтанд Ашигт малтмал эрх хайх үйл ажиллагаа эрхлэгч нь Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд хамаарахгүй гэсэн заалтыг зөрчсөн байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих сангийн зээлийг 3-5 жилийн хугацаатайгаар, хүү багатай өгч байгаа ч хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэд маань зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үйлдвэрлэлийг бий болгох, өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлж тогтворжуулах талаар хангалтгүй ажиллаж байна. Иймээс зөвхөн зээлийг өрхийн орлого олох хэлбэрээр явуулахаас хэтэрдэггүй байна. Энэ нь зээлийн хэрэгжилт үр дүнг шалгахад зээлэнд хамрагдагсад нь ажлын байр нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлээ өргөжүүлэх тал дээр дорвитой алхам хийж чадахгүй зөвхөн зээлэнд хамрагдсан чиглэл нарийн боов, модон эдлэлийн цех, эсгий, оёмол, нэхмэл бүтээгдэхүүн, үндэсний гутлын цех зэрэг өрхийн үйлдвэрлэлүүд ажиллаж байна. Зарим нь зөвхөн тоног төхөөрөмж, ажлын байр төдий байна

Жижиг, дунд үйлдвэр хөгжиж, үр өгөөжөө өгч тэд зах зээлд өөрийн байр суурийг эзлэн өрсөлдөх чадвартай байж, ДНБ –ний үйлдвэрлэлд зохих хувь нэмэр оруулж байна уу? гэсэн үр дүнг хэмжихэд хүндрэлтэй байсан ба “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуульд заасан томъёоллын дагуу статистикийн мэдээлэл гардаггүй учраас нарийвчлан гаргах боломжгүй байгаа хэдийч 2011-2013 онд хөнгөлөлттэй зээлэнд хамрагдан төслөө амжилттай хэрэгжүүлэн үр өгөөжийг нь хүртэж буй ААН иргэдээс дурьдвал иргэн Т.Батсайхан нь 2011 онд 70.0 сая төгрөгийн зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөж үйлдвэрлэлийн зориулалт бүхий ажлын байртай болсоноор 10.0 мянган хос гутал үйлдвэрлэж ОХУ, Хятад улс болон дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлж төвийн бүсийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан байна.

2011 онд “Нарны титэм” ХХК нь Зуунмод суманд замаскны үйлдвэрийг байгуулж жилд 70 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2013 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан Борнуур сумын “Эрээн хавирага” ХХК шуудай, сав баглаа боодлын үйлдвэр, Зуун мод суманд иргэн Ч.Мөнхэрдэнэ нь орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх Лазер сийлбэрийн цехыг тус тус шинээр бий болгож үйл ажиллагаагаа эхлээд байна.

2.1 Сангийн хөрөнгө зарцуулалтанд дотоод хяналт огт хийгдээгүй байна.

Сангаас олгогдож байгаа зарцуулалтанд дотоод хяналт шалгалт огт хийгдээгүй байгаа ба аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний тайлбараар зээл олголт орой хийгдсэн учраас зээлийн ашиглалт бүрэн хэрэгжиж эхлээгүй учраас 2014 онд хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн байна.

2.2 Сангийн үйл ажиллагаанд хяналт үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгогдсон зээлийн зориулалт хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий ХХААЖДҮГ болон Хөдөлмөрийн хэлтэс нь хяналт тавьж ажиллаагүйгээс зээлэнд хамрагдсан ААН иргэд нь ажлын байр нэмэгдүүлээгүй, зээлийг зориулалт бусаар ашиглах зэрэг нэлээд зөрчлүүд гарсан байна. Суманд хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт зээлийн эргэн төлөлтөнд сум орон нутгаас тавьж буй хяналт сул байна.

Зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд орон нутгийн зүгээс тавьж буй хяналт хангалтгүй, гэрээнд аливаа эрсдлийг банк хариуцна гэж заасны дагуу банк хяналтын үүргийг гүйцэтгэж байна. Банкны хяналт нь зөвхөн зээлийн эргэн төлөлтөд чиглэгдэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт өгч байна.

1. Сангийн хөрөнгөөр олгогдож байгаа зээл журмын дагуу явагдаж байна.
2. Сангийн хөрөнгө зарцуулалтанд дотоод хяналт шалгалт огт хийгдээгүй байна.
3. Зарим зээл зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.
4. Хөдөлмөрийн хэлтэс нь сангийн үйл ажиллагааны үр дүнг нарийвчлан тооцохгүй банкны сангаас олгосон зээлийн судалгаагаар ажлын байрны тоо, зээлийн хэмжээ зэргийг гаргаж тухайн зээлийн ашиглалт, үр дүнг тооцож хүрсэн түвшин зэргийг гаргаж ажиллахгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн: Хөдөлмөрийн хэлтсийн дарга Л.Болдбаатар танаа

1. Дотоод хяналт шалгалтыг хуваарийн дагуу хийж, зээлийн ашиглалт, хугацаа хэтэрсэн зээлийн судалгаа, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа зэрэгт үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байх.
2. Сангаас олгож буй зээлийн эргэн төлөлт, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах
3. Олгогдож буй зээл төсөл хөтөлбөр төслүүдийн хэрэгжилтэнд тавих хяналт шалгалтыг сайжруулах.

Аудитор

Г.Бадар-Ууган

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал